



## ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны  
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ГСАТАГ-2019/5/СТА-ОНӨААН

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Чойр хот)  
2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156

Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179

Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Аудитор: Б.Анхтуяа

Утас: 70543179

Цахим хаяг: [ankhtuyab@audit.gov.mn](mailto:ankhtuyab@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан.....	5
2.1.	Оршил.....	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	9
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	11
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11-11
2.11.	Шилэн дансны мэдээлэл .....	13
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	13
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	13
3	Менежментийн захидал .....	14-16
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	18
4.4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан.....	17
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан .....	18
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан .....	19
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	20



“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

## Аудитын гэрчилгээ


---



тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА





## Аудитын тайлан

### 2.1. Оршил

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын захирал Ц.Энхбаатарт танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС/УСНББОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж,



байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Анхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, УСНББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

"Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Орон нутгийн ард иргэдийг тохитой, аюулгүй, цэвэр эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрэн бүрэлдүүлэх, иргэдийг усан хангамжаар хангаж ажиллахад оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

"Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:



- Хог цэвэрлэгээ, булшлах, устгах, Нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, арчилгаа, гэрэлтүүлэг
- Ус хуримтлуулах

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ -ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ -ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Тохижилт Сүмбэр” ОНӨӨТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Гүүк софт” компанийн “AXPLEROR” програм хангамж ашигладаг байна.





“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ -ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Нийт зардал”-ын 1 хувиар сонгов.

“Нийт зардал”-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Материаллаг байдлын суурийг үр дүнгийн тайлангийн зардлаас тооцох нь оновчтой гэж үзсэнтэй холбоотой юм.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны нийт зардал 950,090.2 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 9,500.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан, зөвлөмжийн хэрэгжилттэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд



тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 3 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

### 2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан, өглөгийн тодруулга тайланд 658.8 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэсэн
- Үндсэн хөрөнгийн тайланд 14,849.5 мянган төгрөгийн дахин үнэлгээний бичилт буруу хийсэн
- Орлого, үр дүнгийн тайлангийн зардлыг 66,657.0 мянган төгрөгөөр ангилал зөрүүтэй тайлагнасан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

### 2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй  
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	4,586.4	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	281.5	
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	4	4,867.9	

#### 2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:



#### 2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Тайлант онд 658.8 мянган төгрөгийн өглөг дутуу бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

#### 2.8.1.2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

Орлого, үр дүнгийн тайланд 66,657.0 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2-д заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

#### 2.8.1.3 Балансын данстай холбоотой асуудал

Тайлант онд 14,849.5 мянган төгрөгий үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг буруу бичилтээр тайлагнасан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулав.

#### 2.8.1.4 Зардлын данстай холбоотой асуудал

Тээвэр шатахууны тайлангийн спидометрийн заалт давхардуулж 200.0 мянган төгрөгийн зарлага гаргасан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулж зарлага болгосон 200.0 мянган төгрөгийг холбогдох этгээдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

#### 2.8.1.5 Зардлын данстай холбоотой асуудал

Ажилтанд үндсэн цалин, ээлжийн амралтын цалинг давхардуулан 81.5 мянган төгрөгийг илүү олгосон байна.



Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 81.5 мянган төгрөгийг холбогдох этгээдээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

## 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал илрээгүй болно.

## 2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Тохижилт-Сүмбэр ОНӨААТҮГ”-т өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 277,544.8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	277,544.8	276,229.5	99.5%	1,315.3
1.1	Урсгал зардал	277,544.8	276,229.5	99.5%	1,315.3
1.2	Хөрөнгийн зардал				
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл				
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	277,544.8	276,229.5	99.5%	1,315.3
2.1	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236,541.2	235,460.4	99.5%	1,080.8
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	41,003.6	40,769.1	99.4%	234.5

Тайлант онд өөрийн орлогын төлөвлөгөө 61,500.0 мянган төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 64,318.6 мянган төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 2,818.6 мянган төгрөгөөр буюу 4.4%-иар давуулан биелүүлсэн байна.

Тайланд онд урсгал үйл ажиллагааны зардалд 276229.5 мянган төгрөгийг зарцуулж цалин болон НДШ-ийн зардлаас 329.4 мянга, байр ашиглалтын зардлаас 783.0 мянга, хангамжийн материалын зардлаас 0.3 мянга, эд хогшил, урсгал засварын зардлаас 0.8 мянга, томиллолт, зочны зардлаас 11.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний



төлбөр хураамж зардлаас 190.4 мянга, нийт 1,315.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 236,541.2 мянга, ОНХС-гаас санхүүжилт 41,003.6 мянга, хог хаягдал гаргасны төлбөрийн орлого 55,392.8 мянга, усны орлого 9,131.0 мянга, аймгийн Автозамын сангаас санхүүжилт 39,132.3 мянга, үнэ төлбөргүй авсан үндсэн хөрөнгө 130,322.6 мянга, хүү торгуулийн орлого 67.1 мянга, нийт 511,590.6 мянган төгрөгийн орлогыг тусгасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн санхүүжилт 236,541.2 мянга, ОНХС-гаас санхүүжилт 41,003.6 мянга, хог хаягдал гаргасны төлбөрийн орлого 55,657.9 мянга, усны орлого 3,000.0 мянга, аймгийн Автозамын сангаас санхүүжилт 39,132.3 мянга, нийт 381,466.1 мянган төгрөгийг орлогыг тусгасан байна.

Тайланд хугацаанд авлагын эхний үлдэгдэл 6,473.4 мянган төгрөг байснаас хог хаягдал гаргасны төлбөрийн авлага 265.1 мянган төгрөгөөр буурч, байгууллагаас авах авлага 36,4 мянга, ажиллагчидтай холбогдсон авлага 33.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 6,277.9 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Тайланд хугацаанд өглөгийн эхний үлдэгдэл 615.1 мянган төгрөг байснаас байгууллагад өгөх өглөг 247.8 мянга, хувь хүнд өгөх өглөг 1.2 мянга, нийт 249.0 мянган төгрөгөөр хасагдаж, ХХОАТ-ын өглөг 259.3 мянга, байгууллагад төлөх өглөг 2,789.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 3,415.1 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

2018 онд 19,183.0 мянган төгрөгийн бараа материалын эхний үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр 79,559.7 мянган төгрөгийн бараа худалдан авч, 84,890.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 13,852.4 мянган төгрөгийн бараа материалыг үлдэгдлээр тайлагнасан байна.

2018 онд 7,536,906.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байснаас аймгийн ИТХТ-ийн 2018.12.26-ны өдрийн 50 дугаар тогтоолоор БОАЖГ-аас 20,000.0 мянга, аймгийн ИТХТ-ийн 2018.08.23-ны өдрийн 23 дугаар тогтоолоор 29,729.3 мянга, аймгийн ИТХТ-ийн 2018.12.26-ны өдрийн 50 дугаар тогтоолоор 65,743.8 мянга, дахин үнэлгээний нэмэгдэл 86,189.5 мянга, төсвийн хөрөнгөөр 1,435.0 мянга, нийт 203,097.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, дахин үнэлгээний хорогдол 42,402.3 мянга, оны эцэст 7,697,601.7 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар аймгийн ОНХС-гаас санхүүжилт 41,003.6 мянга, Авто замын сангаас санхүүжилт



39,132.3 мянга, нийт 80,135.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 146 мэдээллийг 100 хувь хугацаа хоцроолгүй мэдээлсэн байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн №69 дугаартай албан тоотоор мэдээлсэн ба мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



## Менежментийн захидал

---

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.



## 1.1 ЗАРДЛЫН ТАЛААР

### Илрүүлэлт

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг илүү, дутуу тооцсон байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### Зөвлөмж

Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийн хэмжээг хуулийн дагуу үнэн зөв тооцох

### Хариуцах ажилтан

Дарга Ц.Энхбаатар  
Нягтлан бодогч Т.Энхтуяа

### Эрсдэл

Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүйгээс төлбөрийн акт тогтоох

### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн





### 3.2 Зардлын талаар

#### Илрүүлэлт

Орлого, үр дүнгийн тайлангийн зардлыг ангилал зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудыг зөрчсөн байна.

#### Зөвлөмж

Орлого үр дүнгийн тайлангийн зардлыг бодит гарсан зардлаар нь тайлагнах

#### Хариуцах ажилтан

Дарга Ц.Энхбаатар  
Нягтлан бодогч Т.Энхтуяа

#### Эрсдэл

Санхүүгийн тайлан хууль журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн



### 1.3 ЗАРДЛЫН ТАЛААР

#### Илрүүлэлт

Бараа материалыг ангилал зөрүүлж орлогоор бүртгэсэн байна.

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

#### Зөвлөмж

Бараа материалыг тохирох ангилалд үнэн зөв бүртгэх

#### Хариуцах ажилтан

Дарга Ц.Энхбаатар  
Нягтлан бодогч Т.Энхтуяа

#### Эрсдэл

Санхүүгийн тайлан хууль журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

#### Төсвийн захирагчийн хариу

Хүлээн зөвшөөрсөн



#### 4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	1/1/2018	12/31/2018
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>	<b>25,706,422.9</b>	<b>20,130,305.35</b>
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.4	Бусад авлага	6,473,390.90	6,277,905.35
1.1.6	Бараа материал	19,183,032.0	13,852,400.0
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	50,000.0	
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>25,706,422.90</b>	<b>20,130,305.35</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>5,637,268,864.48</b>	<b>5,285,216,823.13</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,607,874,967.25	5,157,550,337.60
1.2.2	Биет бус хөрөнгө	29,393,897.23	127,666,485.53
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>5,637,268,864.48</b>	<b>5,285,216,823.13</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,662,975,287.38</b>	<b>5,305,347,128.48</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	<b>615,147.10</b>	<b>3,415,132.10</b>
2.1.1	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>615,147.10</b>	<b>3,415,132.10</b>
2.1.1.1	Дансны өглөг	615,147.10	3,155,795.10
2.1.1.2	Цалингийн өглөг		10.0
2.1.1.3	Татварын өр		259,327.0
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>615,147.10</b>	<b>3,415,132.10</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>615,147.10</b>	<b>3,415,132.10</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>5,662,360,140.28</b>	<b>5,301,931,996.38</b>
2.3.1	Өмч:-төрийн	2,13,0662,208.14	2,202,002,208.14
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	73,800.00	6,805,330.88
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,531,624,094.14	3,093,124,457.36
2.3.10			-438,499,636.78
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>5,662,360,140.28</b>	<b>5,601,931,996.38</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,662,975,287.38</b>	<b>5,305,347,128.48</b>



#### 4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	99,718,750,583.55	5,511,590,609.00
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>		
8	Бусад орлого	971,875,058.55	511,590,609.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	887,474,040.26	950,090,245.78
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	84,401,018.29	(438,499,636.78)
19	Орлогын татварын зардал		
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	84,401,018.29	(438,499,636.78)
21	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	84,401,018.29	(438,499,636.78)
23	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	99,718,750,583.55	511,590,609.00
25	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>		



### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	20.... оны ...-р сарын ...-ний үлдэгдэл	2,130,662,208.14	73,838.00	3,531,624,094.14	5662360140.28
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
9	20.... оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	2,130,662,208.14	73,838.00	3,531,624,094.14	5,66,2360,140.28
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				
11	Залруулсан үлдэгдэл				
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(438,499,636.78)	(438,499,636.78)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				
14	Өмчид гарсан өөрчлөлт				
15	Зарласан ногдол ашиг				
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	71,340,000.00	6,731,492.88		78,071,492.88
17	20.... оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	2,202,002,208.14	6,805,330.88	3,093,124,457.36	5,301,931,996.38



#### 4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>396,437,748.30</b>	<b>381,466,086.00</b>
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	322,504,348.00	316,677,141.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	73,933,400.30	64,788,945.00
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>396,437,748.30</b>	<b>381,466,086.00</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	180,831,838.00	182,642,512.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	23,237,214.00	24,534,075.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	23,262,102.00	25,553,031.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	56,573,519.00	66,179,146.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	11,2533,075.30	82,557,322.00
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>7</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>0</b>